



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023 оны 03 сарын 29-ны өдөр

Дугаар 01

Орхон аймаг

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу Усны газрын гаргасан 2023 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Сэлэнгэ голын сав газрын 2023 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн А/03 тоот ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн Ус ашиглуулагчийг төлөөлж Сэлэнгэ голын сав газрын захиргааны усны барилга байгууламж, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус ашиглалтын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Н.Эрдэнэчимэг, Ус ашиглагчийг төлөөлж Орхон аймаг Баян-Өндөр сум Хүрэнбулаг баг 9011622081 улсын бүртгэлийн дугаартай, 2074192 регистрийн дугаартай "Эрдэнэт үйлдвэр" Төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий инженер Т.Батмөнх нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

### ХОЁР. ГЭРЭЭНИЙ ГОЛ НӨХЦӨЛ

- 2.1. Ус ашиглах зориулалт: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар  
2.2. Ашиглах усны хэмжээ: 22,449,280.0 м<sup>3</sup>/жил- 61504 м<sup>3</sup>/хоног  
2.2.1. унд-ахуй, м<sup>3</sup>/хоног – 378,530.0 м<sup>3</sup>/жил-1037.06 м<sup>3</sup>/хоног  
2.2.2. үйлдвэрлэл, м<sup>3</sup>/хоног- 21,868,193.0 м<sup>3</sup>/жил-59,912.8 м<sup>3</sup>/хоног  
2.2.3. үйлчилгээ, м<sup>3</sup>/хоног- 202,557.0 м<sup>3</sup>/жил- 554.95 м<sup>3</sup>/хоног  
2.3. Усны чанар, найрлага: Булган аймгийн Хангал сумын нутаг Ахай гүний хошууны газрын доорх ус нь MNS 900:2018 стандартын шаардлага хангасан.  
2.4. Усны эх үүсвэрийн:

Байршил: Сэлэнгэ мөрний сав газарт Булган аймгийн Хангал сумын нутаг Ахай гүний хошуу.

Солбилцол: X104°21'32.34" ; Y49°30'50.57"

Барилга байгууламж: "Эрдэнэт-үйлдвэр" ТӨҮГ-ын Ус хангамжийн цехийн ус олборлох гүний 24 худаг, ус өргөх II, III, IV станц, 10000 м<sup>3</sup> багтаамжтай 6 ширхэг төв усан сан. Уулын баяжуулах үйлдвэрээс хойш 5.0 км-т 970,0 сая.тн булингын багтаамж бүхий хаягдлын сан, тус бүр нь 10000 м<sup>3</sup> багтаамжтай 2ш эргэлтийн усан сантай. Ил уурхайн шүүрлийн усыг зумпфэнд хуримтлуулан технологид нэмэлтээр ашигладаг.

Тоног төхөөрөмжийн нэр, марк: SIEMENS UPA-300-94/5 маркын 24-н ширхэг гүний насос, ЭБАРА 400x300 SPD2M маркийн 12 ширхэг насос, УДВ-7А300Н-100-150 маркийн халдваргүйжүүлэх 10 ширхэг төхөөрөмжтэй.

Хүчин чадал: 766 л/сек

2.5. Хаягдал усны: Шавхан зайлуулах

Хэмжээ: 448200 м<sup>3</sup>/жил

Стандартын шаардлага: Байгальд хаядаггүй.



Хаях цэгийн байршил: Баяжуулах үйлдвэрийн Хаягдлын аж ахуйн даланд.  
Солбилцол: E104<sup>08</sup>'00.1" ; N49<sup>01</sup>'55.00" Z1205

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ: Үйлдвэрийн технологийн эргэлтийн усны шаардлагыг хангасан.

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх арга, цэвэрлэгээний түвшин: Солбилцол: E104<sup>04</sup>'6"; N49<sup>04</sup>'9'.00" Z1205.88  
Хоногт 24000м<sup>3</sup> ус цэвэрлэх хүчин чадалтай, механик, биологи, гүн цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх гэсэн технологийн дамжлагатай MNS 6561:2015, MNS 4943:2015 стандартыг хангасан, 90-98% хүртэл цэвэрлэсэн усыг Хангалын голд болон Баяжуулах үйлдвэрийн Хаягдлын аж ахуйн Даланд нийлүүлж байна.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

2.9. Усны тоолуурын:

Төрөл, нэр, дугаар: Усны эх үүсвэр "Эрдэнэт-үйлдвэр" ТӨҮГ-ын Ус хангамжийн цехийн ус өргөх 2 дугаар станцад шингэний зарцуулалт хэмжигч хэт авианы өндөр нарийвчлалтай, баталгаажсан тоолуур суурилагдсан.

Гэрчилгээний дугаар: 025967,025969, 00214904

Загвар: Панаметрикс фирмийн DF-868

Тоолуурын тоо: 2 ширхэг

Суурилуулсан байгууллага, огноо: "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ Цахилгаан цех 2021 оны 05 дугаар сарын 15-ний өдөр /2907 /

2022 оны 08 дугаар сарын 01-ны өдөр / 2903,2904/

Баталгаажуулсан байгууллага, огноо: Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн газар 2021 оны 05 дугаар сарын 14-ний өдөр, /2907/

2022 оны 07 сарын 29-ны өдөр, /2903,2904/ Улаанбаатар хот

Тоолуурын заалт: 00

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Нэг шоометр /м<sup>3</sup>/ ус ашиглахад ноогдох төлбөрийг Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, Засгийн газрын 2011 оны 302, 2013 оны 326, 327 дугаар тогтоол, 2022 оны 416 дугаар тогтоолд заасан ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр, усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг үндэслэн тооцно. Сэлэнгэ мөрний сав газрын экологи эдийн засгийн үнэлгээ 4072 төгрөг/м<sup>3</sup>.

Ашигт малтмал баяжуулахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$4072\text{төг/м}^3 \times 0.2 \times 1.2 = 977.28\text{ төг/м}^3$$

35% - 416-р тогтоолын 7а-д заасан төлбөр тооцох хувь хэмжээ

1.2 – зэсийн баяжмал үйлдвэрлэхэд газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$17,950,897.0\text{м}^3 \times 1710.24\text{төг/м}^3 = 30,700,342,085.28\text{төг}$$

Эрчим хүчний үйлдвэрлэлд газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$4072\text{төг} \times 0.15 \times 0.1 = 61.08\text{төг/м}^3$$

15% - 326-р тогтоолын 8-д заасан төлбөр тооцох хувь хэмжээ

0.1 – Эрчим хүч үйлдвэрлэхэд газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$3,889,064.0\text{м}^3 \times 61.08\text{төг/м}^3 = 237,544,029.12\text{төг}$$

БҮРТГЭ  
ЭТ ҮЙЛ  
ЛИЙН Х  
ТОО

Барилга, барилгын материалын үйлдвэрлэлд газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:  $4072\text{төг} \times 0.2 \times 0.2 = 162.88\text{төг}/\text{м}^3$

20% - 326-р тогтоолын 3-д заасан төлбөр тооцох хувь хэмжээ

0.2 – Барилга, барилгын материалын үйлдвэрлэхэд газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$28,232.0\text{м}^3 \times 162.88\text{төг}/\text{м}^3 = 4,598,428.16\text{төг}$$

Ашиг олох зориулалтаар үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:  $4072\text{төг} \times 0.15 \times 0.13 = 79.404\text{төг}/\text{м}^3$

15% - 326-р тогтоолын 10-д заасан төлбөр тооцох хувь хэмжээ

1.3 – Ашиг олох зориулалтаар үйлдвэрлэл, үйлчилгээнд газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$202,557.0\text{м}^3 \times 79.404\text{төг}/\text{м}^3 = 16,083,836.028\text{төг}$$

Усыг шавхан зайлуулахад газрын доорх усны нөөц ашигласны төлбөр:

$$4945\text{төг} \times 0.15 \times 1.0 = 741.75\text{төг}/\text{м}^3$$

4945 төг Орхон голын сав газарт тогтоогдсон газрын доорх усны экологи, эдийн засгийн суурь үнэ

15% - 326-р тогтоолын 7в-д заасан төлбөр тооцох хувь хэмжээ

1.0– Ус шавхан зайлуулахад газрын доорх ус ашигласныг тооцох итгэлцүүр

$$448,200.0\text{м}^3 \times 741.75\text{төг}/\text{м}^3 = 332,452,350.0\text{төг}$$

**Нийт төлбөр  $30,700,342,085.28\text{төг} + 237,544,029.12\text{төг} + 4,598,428.16\text{төг} + 16,083,836.028\text{төг} + 332,452,350.0\text{төг} = 31,291,020,729.0\text{ төгрөг}$**

$22940730.8\text{м}^3$  усыг ашиглах,  $448200\text{м}^3$  усыг шавхан зайлуулахад нийт  $31,291,020,729.0$  төгрөг /Гучин нэгэн тэрбум хоёр зуун ерэн нэгэн сая хорин мянга долоон зуун хорин есөн төгрөг/

Ус ашигласны төлбөрийг тооцохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлд заагдсан зориулалтаар ашигласан усны хэмжээг хэрэглэгч байгууллагуудын хэмжих хэрэгслийн заалтаар тооцон гүйцэтгэлээр сар бүрийн 10-ны дотор төлбөрийг Булган аймгийн Төрийн сан банкны 100040000944 тоот дансанд төлнө.

2023 оны Ил уурхайгаас шавхан зайлуулах усны төлбөр  $332,452,350$  төгрөгийг Орхон аймгийн Төрийн сангийн 1210000944 тоот дансанд гэрээний хугацаанд хэсэгчлэн төлнө.

2.11.Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох төлбөрийн хэмжээ:

***2022 оны Хаягдал усны дүгнэлтээр 567838115.77 төгрөг***

#### ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглуулах дүгнэлтэд тусгагдсан “Үйлдвэрлэл үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлэн ашиглах даалгавар, тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ зөвлөмж”-ийг хэрэгжүүлж ажиллах.

3.3. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 36 дугаар тогтоолын 1-д “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ус олборлон түгээх тусгай зөвшөөрлийн хүрээнд Сэлэнгэ

мөрнийн сав газраас олборлож байгаа нийт усны 3 хувийн хорогдол тооцох гэсэн заалтыг хэрэгжүүлэх.

#### ДӨРӨВ. БУСАД

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, ус ашиглах эрхийн бичиг, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн

4.5.2. Аль нэг тал татан буугдсан бол

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг харилцан тохиролцох замаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН.

##### УС АШИГЛУУЛАГЧ :

УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ,  
ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ АЖ АХУЙН УС  
АШИГЛАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

  
Н.ЭРДЭНЭЧИМЭГ  
УСНЫ ЧАНАР ЭКОЛОГИ ТӨЛБӨРИЙН  
АСУУДАЛ ХАРИУЦСАН  
МЭРГЭЖИЛТЭН


  
Д.ОТГОНБАЯР

Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Захиргааны II байр  
Сэлэнгэ голын сав газрын захиргаа  
Харилцах утас: 77362536


##### УС АШИГЛАГЧ:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР

  
Т.БАТМӨНХ  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА


  
Д.ҮҮРИЙНТУЯА  
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

  
Х.БОЛДБААТАР

  
ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЕРӨНХИЙ ЭРЧИМ ЗҮЙЧ

Л.АРИУНБОЛД

УС ХАНГАМЖИЙН ЦЕХИЙН ДАРГА

  
Г.БАТМӨНХ

ИЛ УУРХАЙН ДАРГА

  
Д.НЯМДОРЖ

Хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум,  
Найрамдал талбай  
Харилцах утас: (757) 72120